



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2022 оны 01 сарын 13 өдөр


Дугаар A/05

Улаанбаатар хот

Г Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалт, Захирлын зөвлөлийн 2022 оны 01 дүгээр сарын 04, 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-ын 2.1, 2.2, 3.1.16, 3.1.19 дэх заалтуудыг хавсралтад заасны дагуу өөрчлөн баталсугай.
2. Нэмэлт, өөрчлөлтийг журамд тусган, 2021-2022 оны хичээлийн жилийн хаврын улирлаас эхлэн мөрдөж ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Н.Ганзориг), бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт даалгасугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга (Д.Гэрэлт-Од), бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал нарт үүрэг болгосугай.



367040037



ШУТИС-ийн захирлын 2022 оны 01 дүгээр сарын  
13-ны өдрийн 10 дугаар тушаалын хавсралт

“Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр  
тооцож, үнэлэх журам”-д оруулах нэмэлт, өөрчлөлт

- 2.1 Нэг хичээлийн жилд профессор, багшийн ажлын гүйцэтгэлийн ноогдол тэдгээрийн албан тушаалаас (зөвлөх профессороос бусад) үл хамаарч нийт 20 кредит байна.
- 2.2 Профессор, багш нарын сургалт /А/, эрдэм шинжилгээ, инноваци /Б/ ба сургууль, олон нийтийн үйлчилгээ /В/-ний ажлын ноогдлын харьцаа багшийн албан тушаалын ангиллаас хамаарч дараах хувь, хэмжээтэй байна. Үүнд:

#### **Профессор, багшийн А, Б, В кредит цагийн харьцаа, ноогдол**

Хүснэгт 1

д/д	Албан тушаал	Сургалтын цаг /А/		Эрдэм шинжилгээ, инноваци /Б/		Сургууль, олон нийтийн үйлчилгээ /В/		Нийт ноогдол кредит*
		хувь	кредит	хувь	кредит	хувь	кредит	
1	Салбар /Тэнхимийн эрхлэгч	35/45	7/9	30/30	6/6	35/25	7/5	20
2	Зөвлөх профессор	62.5	10	25	4	12.5	2	16
3	Профессор	55	11	30	6	15	3	20
4	Дэд профессор	65	13	25	5	10	2	20
5	Ахлах багш	70	14	20	4	10	2	20
6	Багш	80	16	10	2	10	2	20
7	Дадлагажигч багш	85	13+4	5	1	10	2	20

Тайлбар: \*Кредитийг цагт шилжүүлэх үндэслэл: 20·48 цаг=960 цаг /Нэг хичээлийн жилийн нийт ажлын цаг/, 960 цаг /42 долоо хоног = 22.85 цаг/нэг долоо хоногт ноогдох ажлын цаг/

3.1.16 Сургалтын мастер нь хичээлийн хөтөлбөрийн дагуу 6 хүртэл кредитийн лабораторийн хичээл зааж болно. 6-аас илүү заасан кредитийн үнэлгээг журмын 2.6 заалтаар тооцно. Бүрэлдэхүүн сургуулийн захирлын туслах, салбар, тэнхимийн эрхлэгчийн туслах, сургалтын албаны ажилтан хичээл заахыг зөвшөөрөхгүй.

3.1.19 Гэрээт багшийн сургалтын ажлын нэг кредитийн үнэлгээг багшийн албан тушаалын 1 кредитийн үнэлгээний 70 хувиар, нэгдсэн шалгалт авсан комиссын гишүүд, гадны байгууллагад ажилладаг эрдэмтэн судлаачдыг



ШУТИС-ийн захирлын 20<sup>22</sup>-оны 01 дугээр сарын  
13.-ны өдрийн 105 дугаар тушаалын хавсралт

урьж, нэг удаагийн лекц уншуулахад олгох хөлсийг журмын 2.6 заалтыг  
баримтлан олгоно.

--- oOo ---



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 26 өдөр


Дугаар A/152

Улаанбаатар хот

### Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалт, Эрдмийн зөвлөлийн 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн 07 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

- “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-д 3.2.2 дахь заалтыг нэмж, 2.2, 2.5, 2.6, 2.9, 2.10, 3.1.2.2, 3.1.5, 3.1.6, 3.1.13, 3.1.15, 3.1.16, 3.2.1, 3.3 дахь заалтуудыг хавсралтад заасны дагуу өөрчлөн найруулсугай.
- “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-ын 2.11 дэх заалтыг хассугай.
- Нэмэлт, өөрчлөлтийг журамд тусган, 3.2.2 дахь заалтыг 2018-2019 оны хичээлийн жилийн хаврын улирлаас, бусад нэмэлт, өөрчлөлтуүдийг 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлаас эхлэн мөрдөж, ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Х.Энхжаргал), Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Намнан), бүрэлдэхүүн сургуулийн захирал нарт даалгасугай.
- Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Х.Энхжаргал), Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал (Т.Намнан), бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал, Эрдэмтэн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.



367000277

“Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр  
тооцож, үнэлэх журам”-д оруулах нэмэлт, өөрчлөлт

- 2.2 Профессор, багш нарын сургалт /А/, эрдэм шинжилгээ, инноваци /Б/ ба сургууль, олон нийтийн үйлчилгээ /В/-ний ажлын ноогдлын харьцаа багшийн албан тушаалын ангиллаас хамаарч дараах хувь, хэмжээтэй байна. Үүнд:

**Профессор, багшийн А, Б, В кредит цагийн харьцаа, ноогдол**

Хүснэгт 1

д/д	Албан тушаал	Сургалтын цаг /А/		Эрдэм шинжилгээ, инноваци /Б/		Сургууль, олон нийтийн үйлчилгээ /В/		Нийт ноогдол кредит*
		Хувь	кредит	хувь	кредит	хувь	кредит	
1	Салбар /Тэнхимийн эрхлэгч	35/45	7/9	30/30	6/6	35/25	7/5	20
2	Зөвлөх профессор	50	6	30	4	20	2	12
3	Профессор	55	11	30	6	15	3	20
4	Дэд профессор	65	13	25	5	10	2	20
5	Ахлах багш	70	14	20	4	10	2	20
6	Багш	80	16	10	2	10	2	20
7	Дадлагажигч багш	85	13+4	5	1	10	2	20

Тайлбар: \*Кредитийг цагт шилжүүлэх үндэслэл: 20·48 цаг=960 цаг/Нэг хичээлийн жилийн нийт ажлын цаг/, 960 цаг/42 долоо хоног = 22.85 цаг/нэг долоо хоногт ноогдох ажлын цаг/

- 2.5 Профессор, багш нар ШУТИС-ийн нэрийн өмнөөс Олон улсын, үндэсний, салбарын эрдэм шинжилгээ, инновацийн ажил гүйцэтгэж байгаа тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн сургалтын /А/ цагийн ноогдлын 30 хүртэл хувийг эрдэм шинжилгээ, инноваци /Б/ цагийн ноогдолд шилжүүлэн тооцохоор гэрээ байгуулан ажиллаж болно. Гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй тохиолдолд 2.3 заалтыг баримтлан тооцно.
- 2.6 Ноогдоос давуулан биелүүлсэн нэг кредитийн үнэлгээг тухайн хичээлийн жилд байгуулсан хамтын гэрээгээр зохицуулна
- 2.9 Хичээлийн жилийн эцэст профессор, багшийн гүйцэтгэсэн сургалтын /А/ цагийг дэд захирал, эрдэм шинжилгээ инновацийн /Б/ цагийг эрдэмтэн нарийн бичгийн дарга, сургууль, олон нийтийн үйлчилгээний /В/ цагийг салбар, тэнхимийн эрхлэгч хийж, дэд захирал хянаж, захирлын тушаалаар баталгаажуулна. Эрдэмтэн нарийн бичгийн даргын сургууль, олон нийтийн үйлчилгээ /В/ цагийн гүйцэтгэлийг Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал хянаж, баталгаажуулна.
- 2.10 Б, В цагийн ажлын агуулгад дурьдагдаагүй ажил, үйлчилгээг сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, улиралд 3 хүртэл кредит тооцож болно.
- 3.1.2.2. Семинарын хичээлийн бүлгийг 30-40, практикийн /дадлага/ хичээлийн бүлгийг 26-30, лабораторийн хичээлийн бүлгийг 20-25 оюутантайгаар тус тус тухайн хичээл, лабораторийн онцлогийг харгалзан зохион байгуулна.

- 3.1.5 Оюутны үйлдвэрлэлийн ба хээрийн дадлага, орчуулгын болон хэлний дадлага удирдахад нэг оюутнаас багшид ноогдох кредитийг дараах томьёогоор тооцно.

$$Ch_H = 0.06 \cdot C_K$$

Энд:  $C_K$ - Тухайн дадлагад харгалзах сургалтын төлөвлөгөөнд заагдсан кредит

Танилцах дадлага удирдсан багшид ноогдох кредитийг дараах томьёогоор тооцно.

$$Ch_\partial = Ch_H \cdot N \cdot \left( \frac{T}{30} \right)$$

$T$ - тухайн дадлагын үргэлжлэх хугацаа, хоногоор,

$N$  - оюутны тоо

Тухайн сургууль дээр хичээл, практикийн хэлбэрээр дадлага удирдан явуулсан бол хичээлийн хөтөлбөр, хуваарийн дагуу 3.1.15-аар кредит цагийг бодож олгоно. Оюутны дадлага удирдсан кредитийг удирдагч багш болон үйлдвэрийн талын удирдагчид хуваан олгох асуудлыг дадлагын онцлогийг харгалзан салбар, тэнхимийн эрхлэгч шийдвэрлэнэ.

- 3.1.6 Зөвлөх багш бүрт диплом хамгаалсан оюутан бүрээс бакалаврын ажилд 0.04, магистрын ажилд 0.16 кредит тус тус тооцно. Профессор, багш нар нь улиралд 5 хүртэл бакалаврын дипломын төсөл, ажил ба магистрын төгсөлтийн ажил удирдана.

- 3.1.13 Доктор, магистр, бакалаврын түвшний сургалтанд онлайн хэлбэрээр суралцаж буй, нэг хичээлээр 40 хүртлэх оюутнуудад хичээл заасан багш нарын кредитийг тооцоходоо өдрийн сургалтын дээрх аргачлалуудаар бодож, гарсан үр дүнг онлайн сургалтын итгэлцүүр ( $Ko/c$ )-ээр үржүүлэн багшид ноогдох кредитийг тооцно. Онлайн сургалтын энэхүү итгэлцүүр нь бакалаврын түвшний сургалтанд  $Ko/c=1.2$ , магистр, докторын түвшний сургалтанд  $Ko/c=1.3$  байна. Онлайн сургалтанд хичээл заасан багшийн үнэлгээг 2.6 заалтаар, сургалтын заавал биелүүлэх кредитээс тусад нь тооцно.

- 3.1.15 Өвөл, зуны сургалтад хичээл заасан багш нарын кредитийн тооцоог доорх томьёогоор бодож, үнэлгээг 2.6 заалтаар, сургалтын заавал биелүүлэх кредитээс тусад нь тооцно. Өвөл, зуны сургалт зөвхөн дээд боловсролын ба мэргэжлийн суурь хичээлүүдээр зохион байгуулагдана.

$$Ch = \sum_{i=1}^n [(Ch_{lects,i} + Ch_{sem,i} + Ch_{lab.dad,i}) \cdot d_i]$$

Энд:

$n$  - багшийн өвөл, зуны сургалтанд заасан хичээлийн тоо,

$i$  - хичээлийн дугаар,

$Ch_{lects,i}$ - Тухайн хичээлийн лекцээс багшид тооцогдсон кредит,

$Ch_{sem,i}$ - Тухайн хичээлийн семинараас багшид тооцогдсон кредит,

$Ch_{lab.dad,i}$ -Тухайн хичээлийн лаборатори ба дадлагаас багшид тооцогдсон кредит,

$d_i$ - Хичээлийн агуулгын түвшинд харгалзах итгэлцүүр:

Дээд боловсролын суурь болон мэргэжлийн суурь хичээлүүдэд  $d_i = 1.0$  байна.

- 3.1.16 Сургалтын мастер нь хичээлийн хөтөлбөрийн дагуу 6 хүртэл кредитийн лабораторийн хичээл зааж болно. 6-аас илүү заасан кредитийн үнэлгээг 3.1.19 заалтаар тооцно. Бүрэлдэхүүн сургуулийн захирлын туслах, салбар, тэнхимийн эрхлэгчийн туслах, сургалтын албаны ажилтан хичээл заахыг зөвшөөрөхгүй.



UNIVERSITY OF TECHNOLOGY AND SCIENCE AND MONOGRAPH

ITA1161 9087087

### 3.2 Эрдэм шинжилгээ, инновацийн ажлын /Б/ кредитийг дараах байдлаар тооцно.

Үүнд:

#### 3.2.1. Эрдэм шинжилгээ, инновацийн ажлыг тооцох үзүүлэлтүүд

Хүснэгт 4

№	Эрдэм шинжилгээний бүтээл	Хэмжих нэгж	Кредит	Тайлбар
<b>I. Гадаадад ЭШ-ний өгүүлэл хэвлүүлэх</b>				
1	Олон улсын мэдээллийн санд /Web of Science, SCOPUS/-бүртгэлтэй мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн.	1 өгүүлэл		1-р зохиогч ба холбоо барих зохиогчид тухайн албан тушаалд харгалзах Б цагийг бутэн тооцно. 2 ба бусад зохиогчид 5 хүртэлх кредитийг тэнцүү хувааж олгоно.
2	Олон улсын мэдээллийн санд /Web of Science, SCOPUS/-бүртгэлгүй боловч мэргэжлийн түвшинд хянаагдаг /peer-review/ сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл		3 кредитийг зохиогчдод тэнцүү хувааж олгоно.
3	ОУ-ын болон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1 өгүүлэл	2/1	
4	Мэргэжлийн түвшинд хянаагдаггүй гадаадын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1	2	
5	Гадаадад зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1	1	
<b>II. Дотоодод ЭШ-ний өгүүлэл хэвлүүлэх</b>				
1	Их сургуулиудын эрдэм шинжилгээний бичигт өгүүлэл хэвлүүлэх	1	1	
2	Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1	1	
3	Дотоодод зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1	1	
4	Дотоодод зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд илтгэлийн хураангуй хэвлүүлэх	1	0.5	
<b>III. Эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэх</b>				
1	Монограф /нэг сэдэвт зохиол/	1 х.х.	0.3	
2	Гадаад хэлээр бичигдсэн монограф	1 х.х.	0.4	
3	Шинжлэх ухааны доктор /Sc.D/-ын диссертаци	1 ажил	7	
4	Доктор /Ph.D/-ын диссертаци	1 ажил	5	
5	Сурах бичиг /ШУТИС-ийн үндсэн сурах бичиг/	1 х.х.	0.2	
6	Орчуулгын бүтээл /ШУТИС-ийн захиалгат/	1 х.х.	0.2	
7	Гарын авлага /лабораторийн заавар тооцогдохгүй/	1 х.х.	0.2	
8	Эшлэл татагдсан бүтээл - Олон улсад - WEB of SCIENCE, SCOPUS	1 эшлэл	0.2/1	
<b>IV. Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх</b>				
1	Олон улсын болон улсын хэмжээний хурал	1 илтгэл	1,5/1	
<b>V. Оюуны өмчийн эрх авах, баталгаажуулах</b>				
1	Шинэ бүтээлийн патент (гадаадад/дотоодод)		5/2	

2	Ашигтай загвар (гадаадад/ дотоодод)	1 бүтээл	3/1
3	Бүтээгдэхүүний загвар (гадаадад/ дотоодод)		3/1
4	Барааны тэмдэгт (гадаадад/ дотоодод)		2/1
5	Зохиогчийн эрх авсан бүтээл		1
V	Бусад		
1	Хөтөлбөр магадлан итгэмжлүүлэх (олон улсын / үндэсний )	1	2/1

### 3.2.2 Төсөл, гэрээт ажил гүйцэтгэх

Хүснэгт 5

№	Төсөл, гэрээт ажил	Хэмжих нэгж	Кредит
1.	ШУТС-ийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл /давхардуулж тооцохгүй/: - Удирдсан - Гүйцэтгэсэн - Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил	
2.	ШУТИС-ийн Технологийн сангийн санхүүжилттэй төсөл, сэдэвт ажил, инновацийн төсөл /давхардуулж тооцохгүй/: - Удирдсан - Гүйцэтгэсэн - Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил	
3.	Төрийн байгууллага, аж ахуйн нэгж, Монгол дахь олон улсын байгууллагын гэрээт, захиалгат болон ШУТИС-аас санхүүжүүлсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажил /давхардуулж тооцохгүй/: - Удирдсан - Гүйцэтгэсэн - Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил	$K_t = \frac{A}{K_p} \cdot 0.2$
4.	Гадаадтай хамтарсан болон олон улсын төсөл /давхардуулж тооцохгүй/: - Удирдсан - Гүйцэтгэсэн - Зөвлөхөөр ажилласан Гадаадтай хамтарсан хөтөлбөр - Удирдсан - Гүйцэтгэсэн - Зөвлөхөөр ажилласан	1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил 1 ажил	

Тайлбар:

- Kt- төсөл, гэрээт ажлын кредит
- A-сургуулийн шимтгэл
- Кр- багшийн нэг өдрийн цалин
- 0.2 итгэлцүүр.

Удирдагч төслийн багийн гишүүдийн оролцоог харгалзан ноогдох кредитийг хуваарилна.

### 3.3 Профессор багш нарын сургууль, олон нийтийн үйлчилгээ /В цаг/-ний ажлын

гүйцэтгэлийг дараах агуулгаар тооцно.

Хүснэгт 6

№	Ажил	Үр дүн*
I	<b>Сургуулийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой ажлууд</b>	
1	ШУТИС-ийн болон бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зөвлөлийн гишүүн /давхардуулж тооцож болно/	0.3
2	Бүрэлдэхүүн сургуулийн захиргааны шийдвэрээр хийсэн ажил: - Сургалт, заах арга, сургалтын технологийг боловсронгуй болгох - Заавар, дүрэм, бусад баримт бичиг боловсруулах - Бусад үүрэгт ажил	0.3
II	<b>Багшийн хөгжил, хамт олны төлөвшилтэй холбоотой ажлууд</b>	
1	Багшийн хичээлд сууж, зөвлөгөө өгөх, эсвэл багшийг дагалдуулах, хичээлд нь суух /1 хичээлийн улиралд/	0.3
2	Нээлттэй хичээл зохион байгуулах	
3	Хамт олны дунд нийгмийн арга хэмжээ зохион байгуулах, оролцох: - Урлагийн үзлэг наадам - Спортын тэмцээн, уралдаан - Хамт олны тэмдэглэлт арга хэмжээ	
III	<b>Оюутан, суралцагчдын хөгжил, төлөвшилтэй холбоотой ажлууд</b>	
1	Оюутны дугуйлан, клуб удирдах, зохион байгуулах	0.3
2	Суралцагчдын хүмүүжил, төлөвшлийн ажил Соёл, олон нийтийн ажил зохион байгуулах	
3	Оюутнуудад давтлага өгөх, тойм лекц үнших	
IV	<b>Сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой ажлууд</b>	
1	Нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх зорилго бүхий эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх	0.3
2	Нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр лекц үнших	
3	ШУТИС-ийн эрдэм шинжилгээний ажлын бүртгэлд тусгагдаагүй эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажилд оролцох	
4	Нийгэм, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа Телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцож, мэргэжлээ сурталчлах, мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгөх Өдөр тутмын сонин хэвлэлд өгүүлэл, нийтлэл бичих Үндэсний зөвлөхөөр ажиллах Шинжээчээр ажиллах Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах /ажлын хөлс авахгүй нөхцөлд/	
5	Салбар /тэнхим/, профессорын багийн болон бусад семинар, лекц, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад оролцсон	0.03
6	Зөвлөх багшаар ажиллах (30 хүртэл/30 дээш оюутан)	1/2
7	Бусад	0.3



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН  
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2018 оны 09 сарын 27 өдөр

Дугаар A/184

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.9.2, 4.14.7, 10.2 дахь заалт, ШУТИС-ийн Захирлын 2018 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн А/159 тоот тушаал, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2018 оны 9 дүгээр сарын 11-ний хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. ШУТИС-ийн Захирлын 2018 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн А/159 тоот тушаалаар батлагдсан “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-ын 3.1.11 заалтыг хавсралтад заасны дагуу өөрчлөн мөрдсүгэй.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал (Х.Энхжаргал), Сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга (Д.Гэрэлт-Од), бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирал нарт даалгасугай.



ШУТИС-ийн Захирлын 2018 оны 09. дүгээр сарын  
27.-ны өдрийн 18:00 тоот тушаалын хавсралт

“ПРОФЕССОР, БАГШ НАРЫН АЖЛЫН ТҮЙЦЭТГЭЛИЙГ  
КРЕДИТЭЭР ТООЦОЖ, ҮНЭЛЭХ ЖУРАМ”-Д ОРУУЛАХ ӨӨРЧЛӨЛТ

3.1.11. Магистр, докторын тувшний сургалтын ажлын багшид ноогдох кредитийг тухайн хичээлийг сонгосон магистрант, докторантын тооноос хамааруулан дараах томьёогоор тодорхойлно.

Магистрант, докторантын тоо  $N_i \leq 15$  бол:

$$Ch = \sum_{i=1}^n \left[ (Ch_{lects,i} + Ch_{sem,i} + Ch_{lab,dad,i}) \cdot d_i \cdot \frac{N_i}{16} + Ch_{z,i} + Ch_{bd,i} \right]$$

Магистрант, докторантын тоо  $N_i > 15$  бол

$$Ch = \sum_{i=1}^n [(Ch_{lects,i} + Ch_{sem,i} + Ch_{lab,dad,i}) * d_i + Ch_{bd,i}] - 0.2$$

Энд:

$n$ - Тухайн улиралд багшийн заасан хичээлийн тоо,

$i$ - Хичээлийн дугаар,

$N_i$ -  $i$ -р хичээлийг сонгосон оюутны тоо,

$Ch_{lects,i}$ -  $i$ -р хичээлийн лекцээс багшид тооцогдсон кредит,

$Ch_{sem,i}$ -  $i$ -р хичээлийн семинараас багшид тооцогдсон кредит,

$Ch_{lab,dad,i}$ - $i$ -р хичээлийн лаборатори ба дадлагаас багшид тооцогдсон кредит,

$Ch_{z,i}$  - $i$ -р хичээлийн багшид ноогдох кредитийн тэнцвэржүүлэгч коэффициент

$$Ch_{z,i} = (16 - N_i) * 0.03 * Ch_{lects,i}$$

$Ch_{bd,i}$ -  $i$ -р хичээлийн бие даалтаас багшид тооцогдсон кредит.

Тухайн хичээлийг сонгосон оюутны бие даалтыг шалгах, шалгалт, сорил, тест авахад нь зориулж, лекцийн 1 кредит тутамд оюутан бүрд 0.02 кредитийг багшид тус тус тооцно.

$d_i$ -  $i$  -р хичээлийн агуулгын тувшинд харгалзах итгэлцүүр,

магистрын хичээлүүдэд  $d_i = 1.4$

докторын хичээлүүдэд  $d_i = 1.5$  байна.



## ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 23 өдөр


Дугаар A/159

Улаанбаатар хот

“Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг  
кредитээр тооцож, үнэлэх журам”-ыг  
шинэчлэн батлах тухай

ШУТИС-ийн дүрмийн 4.14.7, 10.2 дахь заалт, ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай 07 тоот тогтоол, ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2018 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцож, үнэлэх журам”-ын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталж, 2018/2019 оны хичээлийн жилийн намрын улирлаас эхлэн мөрдсүгэй.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжүүлж ажиллахыг Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал /Х.Энхжаргал/, Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал /Т.Намнан/, Захиргаа, хүний нөөцийн газрын дарга /Н.Ганзориг/, бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирлуудад үүрэг болгосугай.



ПРОФЕССОР, БАГШ НАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ  
КРЕДИТЭЭР ТООЦОЖ, ҮНЭЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь ШУТИС-ийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд профессор, багш нарын оруулж буй хувь нэмэр, гүйцэтгэсэн ажлын кредит хэмжээ, үр дүнг тодорхойлж, үнэлэн, урамшуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Шинжлэх ухаан технологийн их сургууль нь сургалт эрдэм шинжилгээний үйл ажиллагаандaa Монгол улсын Үндсэн хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан их сургуулийн бусад дүрэм, журам болон энэхүү журмыг баримтална.
- 1.3. Профессор, багшийн хөдөлмөр нь их сургуулийн З үндсэн үүргийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Үүнд:
  - A. Сургалт
  - Б. Эрдэм шинжилгээ, инноваци
  - В. Сургууль, олон нийтийн үйлчилгээ зэрэг болно.
- 1.4. Энэ журмаар их сургуулийн профессор, багшийн сургалт /A/, эрдэм шинжилгээ, инноваци /B/, сургууль, олон нийтийн үйлчилгээ /B/-ний ажлын гүйцэтгэлийг тооцож, үнэлнэ.
- 1.5. Багшийн сургалтын ажлын гүйцэтгэл нь бакалавр, магистр, докторын сургалтаас бүрдэнэ. Докторын хөтөлбөрт заасан хичээлийн кредитийг А цагийн ачааллын ноогдолд оруулахгүйгээр тусад нь тооцож олгож болно.
- 1.6. Профессор, багшийн сургалт /A/, эрдэм шинжилгээ, инноваци /B/, сургууль, олон нийтийн үйлчилгээ /B/-ний үндсэн нормт кредит цагийн үнэлгээ ижил байна. Профессор, багшийн нэг кредитийн эквивалентийг 48 цагийн хөдөлмөр гэж үзнэ.

ХОЁР. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН АЖЛЫН НООГДОЛ

- 2.1. Нэг хичээлийн жилд профессор, багшийн ажлын гүйцэтгэлийн ноогдол тэдгээрийн албан тушаалаас үл хамаарч нийт 20 кредит /A нормт + Б нормт + В нормт/ байна.
- 2.2. Профессор, багш нарын сургалт /A/, эрдэм шинжилгээ, инноваци /B/ ба сургууль, олон нийтийн үйлчилгээ /B/-ний ажлын ноогдлын харьцаа багшийн албан тушаалын ангиллаас хамаарч дараах хувь, хэмжээтэй байна. Үүнд:

**Профессор, багшийн А, Б, В кредит цагийн харьцаа, ноогдол**

Хүснэгт 1

д/д	Албан тушаал	Сургалтын цаг /A/		Эрдэм шинжилгээ, инноваци /Б/		Сургууль, олон нийтийн үйлчилгээ /В/		Нийт ноогдол кредит*
		Хувь	кредит	хувь	кредит	хувь	кредит	
1	Салбар /Тэнхимиийн эрхлэгч	35/45	7/9	30/30	6/6	35/25	7/5	20
2	Зөвлөх профессор	40	6	40	4	20	2	12
3	Профессор	55	11	30	6	15	3	20
4	Дэд профессор	65	13	25	5	10	2	20
5	Ахлах багш	70	14	20	4	10	2	20
6	Багш	80	16	10	2	10	2	20
7	Дадлагажигч багш	85	13+4	5	1	10	2	20

Тайлбар: \*Кредитийг цагт шилжүүлэх үндэслэл: 20·48 цаг=960 цаг /нэг хичээлийн жилийн нийт ажлын цаг/, 960 цаг /42 долоо хоног = 22.85 цаг /нэг долоо хоногт ноогдох ажлын цаг/

- 2.3. Профессор, багш нар нь өөрийн ажиллаж байгаа албан тушаалд харгалзах кредитийн ноогдлыг бүрэн биелүүлэх үүрэгтэй бөгөөд дутуу гүйцэтгэсэн тохиолдолд нэг кредитийн дундаж үнэлгээгээр үржүүлсэнтэй тэнцүү мөнгөн суутгал хийгдэнэ. Профессор, багш ноогдолт Б цагийн гүйцэтгэлийг биелүүлээгүй тохиолдолд уг ноогдлын 50 хувьд А цагийн гүйцэтгэлээс нөхөн тооцож болно.
- 2.4. Ноогдоос давуулан биелүүлсэн сургалт /A/, эрдэм шинжилгээ, инноваци /B/-ийн ажлын гүйцэтгэлийг илүү кредит цагаар тооцно. Зөвшөөрөгдөх сургалтын ажлын илүү кредит нь тухайн профессор багшийн албан тушаалд харгалзах кредитээс илүүгүй, эрдэм шинжилгээ, инновацийн ажлын илүү кредит нь ноогдлын 50 хувиас хэтрэхгүй.
- 2.5. Профессор, багш нар ШУТИС-ийн нэрийн өмнөөс томоохон эрдэм шинжилгээ, инновацийн ажил гүйцэтгэж байгаа тохиолдолд бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн сургалтын /A/ цагийн ноогдлын 30 хуртэл хувийг эрдэм шинжилгээ, инноваци /B/ цагийн ноогдолд шилжүүлэн тооцохоор гэрээ байгуулан ажиллаж болно. Гэрээнд заагдсан үүргээ биелүүлээгүй тохиолдолд 2.3 заалтыг баримтлан тооцно.
- 2.6. Ноогдоос давуулан биелүүлсэн нэг кредитийн үнэлгээг тухайн хичээлийн жилд захиргаа, ҮЭ-ийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээгээр зохицуулна.
- 2.7. Профессор, багш нар хүрэлцээгүй, өвчтэй, чөлөөтэй байсан зэрэг зайлшгүй шаардлагаас үүдэн эрдэм шинжилгээ, инноваци, сургууль олон нийтийн ажлын кредит нь бүрэн биелэгдсэн профессор, багш нарын сургалтын заавал биелүүлэх ноогдоос давуулан заасан илүү кредит нь тухайн профессор багшийн сургалтын заавал биелүүлэх кредитээс хэтрэхгүй байна.

- Цалинтай бүтээлийн чөлөө авсан багш нарын илүү гүйцэтгэсэн кредитийг үндсэн ноогдоос нь тооцно.
- 2.8. Дадлагажигч багш нь эхний жилдээ өөрийн дагалдан ажиллаж байгаа профессор багшийн 4-өөс доошгүй кредитийн хинээлд сууж зөвлөгөө авах ба энэ нь хичээл заасан цагтай адил тооцогдоно. Дадлагажигч багшид ноогдоос давсан илүү кредитийн хөлсийг олгохгүй.
  - 2.9. Хичээлийн жилийн эцэст профессор, багшийн гүйцэтгэсэн сургалт /А/ ажлын цагийг сургалт эрхэлсэн дэд захирал, эрдэм шинжилгээ инноваци /Б/ ажлын цагийг эрдэмтэн нарийн бичгийн дарга, сургууль, олон нийтийн үйлчилгээ /В/ ажлын цагийг салбар, тэнхимиийн эрхлэгч хянаж, захирлын тушаалаар баталгаажуулна.
  - 2.10. А, Б, В цагийн ажлын агуулгад дурьдагдаагүй ажил, үйлчилгээг сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж гүйцэтгэлийн үнэлгээг тогтооно.
  - 2.11. ШУТИС-ийн Мастер төлөвлөгөөний тодорхой зорилтын хэрэгжилтийг хангах, сургуулийн удирдлагаас бодлогоор даалгасан, нийгэмд үр нөлөө нь мэдрэгдэхүйц ажлын гүйцэтгэл, сургуулийн нэр хүндийг олон улсын болон улсын хэмжээнд өргөсөн онцгой амжилт, бүтээлд сургуулийн захирлын зөвлөлийн шийдвэрээр урамшуулалт олгоно.
  - 2.12. ШУТИС-ийн дэд захирал, газар, албаны дарга, бүрэлдэхүүн сургуулийн захирал нар ШУТИС-ийн захиралтай, бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал нар нь бүрэлдэхүүн сургуулийн захиралтай гэрээ байгуулсны үндсэн дээр салбарын эрхлэгчийн албан тушаалын нормоос хэтрэхгүй сургалтын ажил гүйцэтгэж болох бөгөөд үнэлгээг 2.6 заалтаар тооцно.
  - 2.13. ШУТИС-ийн удирдах албан тушаалтан профессор, багшийн албан тушаалд хавсран ажиллаж болохгүй.
  - 2.14. Бүрэлдэхүүн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга нь хичээлийн жилд сургалт, эрдэм шинжилгээ, инноваци, сургууль олон нийтийн ажлын кредитийн дараах ноогдолтой байх бөгөөд зөвшөөрөгдөх илүү кредит цаг нь тухайн албан тушаалд харгалзах ноогдоос илүүгүй байна.

Хүснэгт 2

Албан тушаал	Сургалтын ажлын кредит	Эрдэм шинжилгээ, инновацийн ажлын кредит	Сургууль олон нийтийн үйлчилгээний ажлын кредит
Бүрэлдэхүүн сургуулийн эрдэмтэн нарийн бичгийн дарга	4	0	6

#### **ГУРАВ. ПРОФЕССОР, БАГШ НАРЫН СУРГАЛТ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, ИННОВАЦИ, СУРГУУЛЬ ОЛОН НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН КРЕДИТИЙН ТООЦОО**

- 3.1. Профессор багш нарын гүйцэтгэсэн сургалтын ажлын кредитийг дараах байдлаар тооцно.
  - 3.1.1. Багшийн сургалтын ажлын гүйцэтгэсэн кредитийг багш нарын заасан бодит гүйцэтгэл кредитээр тооцно. Үүнд:
    - А. Лекцийн хичээл /Лекцийн бүлгийн тоог гаргаж, бодит гүйцэтгэл кредитээр/;

- Бодит гүйцэтгэсэн цаг 16 цаг – 1 кредит.
- B. Семинарын хичээл /Семинарын бүлгийн тоог гаргаж, бодит гүйцэтгэл кредиттээр/;
- Бодит гүйцэтгэсэн цаг 32 цаг – 1 кредит;
- C. Лаборатори ба дадлагын хичээл /Лаборатори, дадлагын бүлгийн тоог гаргаж, бодит гүйцэтгэл кредиттээр/;
- Бодит гүйцэтгэсэн цаг 32 цаг – 1 кредит
- D. Тухайн хичээлийг сонгосон оюутны бие даалтыг шалгах, шалгалт, сорил, тест авахад нь зориулж, лекцийн 1 кредит тутамд оюутан бүрд 0.01 кредитийг багшид тус тооцно.

Тухайн улиралд багшид ноогдох нийт кредитийг дараах илэрхийллээр бодно.

$$Ch = \sum_{i=1}^n [(Ch_{lects,i} + Ch_{sem,i} + Ch_{lab.dad,i}) \cdot d_i + Ch_{bd,i}]$$

Энд:

n - Тухайн улиралд багшийн заасан хичээлийн тоо;

i - Хичээлийн дугаар;

$Ch_{lects,i}$  - i-р хичээлийн лекцээс багшид тооцогдсон кредит;

$Ch_{sem,i}$  - i-р хичээлийн семинараас багшид тооцогдсон кредит;

$Ch_{lab.dad,i}$  - i-р хичээлийн лаборатори ба дадлагаас багшид тооцогдсон кредит;

$Ch_{bd,i}$  - i-р хичээлийн бие даалтаас багшид тооцогдсон кредит;

$d_i$  - i-рхичээлийн агуулгын түвшинд харгалзах итгэлцүүр:

Дээд боловсролын суурь  $d_i = 1.0$

Мэргэжлийн суурь хичээлүүдэд  $d_i = 1.0$

Мэргэжлийн хичээлүүдэд  $d_i = 1.2$

байхаар итгэлцүүрийг сонгож авна.

- 3.1.2. Профессор багшийн бодит гүйцэтгэлийн кредит  $Ch_{tech}$ -ийг багшид ноогдох кредит Ch, чанарын үзүүлэлтийн коэффициент  $k_{ch}$ -ийн үржвэр:

$$Ch_{tech} = Ch \cdot k_{ch}$$

байдлаар тодорхойлж багшид олгоно.  $k_{ch}$ -хичээлийн чанарын үзүүлэлтийн коэффициентийн утга нь  $0.9 \leq k_{ch} \leq 1.0$  байна.

Тухайн хичээлийн жилд сургалтын талаар баримтлах бодлоготой уялдуулан сургуулийн захиргаанаас чанарын коэффициентийг тооцох шалгуур үзүүлэлтүүдийг тогтооно.

Нэмэлт тайлбар:

- 3.1.2.1. Бакалаврын түвшний сургалтад 30 оюутныг хичээлийн үндсэн анги болгон тооцож, сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан тухайн хичээлийн кредитийг багшид бүрэн олгох зарчим баримтална. Үндсэн бүлгийн энэхүү кредит нь багшийн багц хөдөлмөрийг илэрхийлнэ. Үүнд: Тухайн хичээлийн лекц, лаборатори, семинар, дадлагын хичээл, бие даалт, иж бүрэн тест, явцын сорил, улирлын шалгалт, тусдаа сургалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй курсын төсөл, ажил болон хичээлийн е-файл бүрдүүлэлт зэрэг байна.

- 3.1.2.2. Семинарын хичээлийн бүлгийг 30-40 оюутантайгаар, дадлага ба лабораторийн хичээлийн бүлгийг 20-25 оюутантайгаар тухайн хичээл, лабораторийн онцлогийг харгалzan зохион байгуулна.
- 3.1.2.3. Бакалаврын сургалтын зарим мэргэжлийн хичээлүүдийн онцлогийг харгалzan 20-оос доош оюутантайгаар, мэргэжлийн хичээлүүдийн дадлага, лабораторийн бүлгийн оюутны тоог дээр зааснаас цөөрүүлэн хичээллүүлэхийг тухайн сургуулийн захирлын зөвлөлөөр хэлэлцэж, тушаал гарган шийдвэрлэнэ. Тухайн хичээлд хамрагдах бакалавр оюутны тоо 15 болон түүнээс бага байвал багшид ноогдох кредитийг 3.1.11 заалтаар бодож, бие даалтыг шалгах, шалгат, сорил, тест авахад нь зориулж, багшид тооцогдох кредит нь 3.1.1.D заалтаар зохицуулагдана.
- 3.1.2.4. Дээр заасан үндсэн зарчмуудыг баримтлан тухайн сургуулийн анги танхимиын хүрэлцээ, хичээлийн онцлог байдал, хичээл сонгосон оюутны тоо зэргийг үндэслэн сургалтын асуудал эрхэлсэн захиргаанынэгжээс хичээлийн хуваарийг гаргана.
- 3.1.2.5. Оюутны тоог тооцоходоо хичээлийн тухайн улирлын V долоо хоногийн төгсгөлд кредит баталгаажуулсан захирлын тушаалд орсон оюутны тоо, нэрсийн жагсаалттай тулгаж тооцно.
- 3.1.2.6. ШУТИС-ийн нэрийн өмнөөс өөрийн биеэр болон баг тамирчид бэлтгэн оролцуулж олон улсын тэмцээнээс медаль хүртсэн тохиолдолд 2,0 кр хүртэл, улсын аварга шалгаруулах тэмцээн 1,5 кр хүртэл, бус болон хотын аварга шалгаруулах тэмцээн уралдаанаас шагнал хүртсэн тохиолдолд 1 кредитийг удирдсан багш-дасгалжуулагчийн сургалтын ажлын ноогдолд тооцно. Бүрэлдэхүүн сургуулиудын шигшээ багийн бэлтгэл сургуулилалтыг хичээллүүлж, ШУТИС-ийн аварга шалгаруулах тэмцээнд шагналт байрт шалгарсан тохиолдолд сургалтын ажлын заавал биелүүлэх ноогдолд, шалгараагүй тохиолдолд эрдэм шинжилгээ, бүтээлч ажлын ноогдолд 1 кредитийг тус бүр тооцно. Дээрх заалтаар тооцогдох кредит нь багшийн сургалтын ажлын заавал биелүүлэх ноогдлын 30 хүртэл хувиас хэтрэхгүй байна. Бэлтгэл сургуулилалтын оюутны тоог жич тогтооно.
- 3.1.2.7. Нэг хичээлийг хэд хэдэн багш багцлан заасан тохиолдолд багшид ноогдох нийт кредитийг дээр заасан томъёо, аргачлалаар бодож, нийлбэр кредитийг багш наарт хуваах асуудлыг багш нарын оролцоо, оюутны тоо зэргийг харгалzan тухайн салбар, тэнхимиин эрхлэгч шийдвэрлэнэ.
- 3.1.3. Бакалаврын дипломын төсөл, ажлын удирдагч багшид олгох кредитийг дараах томъёогоор тооцно.
- $$Ch_p = 0.08 \cdot C_p$$
- Энд:  $C_p$ -Бакалаврын дипломын төсөл, ажилд харгалзах сургалтын төлөвлөгөөнд заагдсан кредит
- 3.1.4. Сургалтын төлөвлөгөөнд тусдаа тусгагдсан оюутны курсын төсөл, ажил удирдаж хамгаалуулах, магистрын туршилт судалгааны ажил гэх мэт оюутантай ганцаарчлан ажиллахад олгох кредитийг дараах томъёогоор тооцно.
- $$Ch_k = 0.06 \cdot C_k$$



ШУТИС-ийн Захирлын 2018 оны 08 дугаар сарын  
23-ны өдрийн 11:59, тоот тушаалын хавсралт

Энд:

$C_k$  - Курсын төсөл, ажил гэх мэт ганцаарчилсан сургалтын ажилд харгалзах сургалтын төлөвлөгөөнд заагдсан кредит

- 3.1.5. Оюутны үйлдвэрлэлийн ба хээрийн дадлага, багшах дадлага удирдахад нэг оюутнаас багшид ноогдох кредитийг дараах томьёогоор тооцно.

$$Ch_H = 0.06 \cdot C_k$$

Энд:  $C_k$ - Тухайн дадлагад харгалзах сургалтын төлөвлөгөөнд заагдсан кредит

Танилцах дадлага удирдсан багшид ноогдох кредитийг дараах томьёогоор тооцно.

$$Ch_d = Ch_H \cdot N \cdot \left(\frac{T}{30}\right)$$

$T$ - тухайн дадлагын үргэлжлэх хугацаа, хоногоор,

$N$  - оюутны тоо

Тухайн сургууль дээр хичээл, практикийн хэлбэрээр дадлага удирдан явуулсан бол хичээлийн хөтөлбөр, хуваарийн дагуу 3.1.15-аар кредит цагийг бодож олгоно.

Оюутны дадлага удирдсан кредитийг удирдагч багш болон үйлдвэрийн талын удирдагчид хуваан олгох асуудлыг дадлагын онцлогийг харгалзан салбар, тэнхимийн эрхлэгч шийдвэрлэнэ.

- 3.1.6. Бакалаврын дипломын төсөл, ажилд удирдагч багшаас гадна албан ёсны зөвлөх 2 хүртэл багшийг, мэргэжлийн магистрын судалгааны ажилд удирдагч, судлаач магистрын төгсөлтийн ажилд удирдагчаас гадна албан ёсны нэг зөвлөхийг ШУТИС-ийн захирлын тушаалаар томилон ажиллуулна. Зөвлөх багшид диплом хамгаалсан оюутан бүрээс бакалаврын ажилд 0.04, магистрын ажилд 0.16 кредит тус тус тооцно. Профессор, багш нар нь улиралд 5 хүртэл бакалаврын дипломын төсөл, ажил ба магистрын төгсөлтийн ажил удирдана.
- 3.1.7. Бакалаврын дипломын төсөл, ажлын шүүмжид 0.03, магистрын төгсөлтийн ажлын шүүмжид 0.06 кредит тус тус тооцно.
- 3.1.8. Бакалаврын дипломын төсөл, ажлын хамгаалуулах төгсөлтийн комиссын гишүүний ажлын хөлсийг хамгаалсан оюутан тус бүрд 0.02 кредит, магистрын төгсөлтийн ажлыг хамгаалуулах зөвлөл, мэргэжлийн нэгдсэн шалгалтын комиссын гишүүний ажлын хөлсийг магистрант тус бүрд 0.03 кредит байхаар тооцож олгоно. Төгсөлтийн салбар комиссын нарийн бичгийн дарга нарт төгсөгч бүрд 0.003 кредит нэмж, төгсөгчийн дүн тулгалт хийсэн тохиолдолд төгсөгч бүрд 0.02 кредит тус тус тооцно. Дипломын төсөл, ажлын урьдчилсан хамгаалалтад тусгайлан кредит тооцохгүй.
- 3.1.9. Бакалаврын төгсөх ангийн оюутан, магистрын гадаад хэлний нэгдсэн шалгалт өгөх магистрант нарт зориулж 1 хүртэл кредитийн давтлага өгөн, тойм лекц уншиж болох бөгөөд багшид ноогдох кредитийг салбар, тэнхимийн эрхлэгчийн баталсан хуваарийн дагуу энэ журмыг баримтлан олгоно.
- 3.1.10. Магистрын төгсөлтийн ажлыг удирдаж буй багшийн кредитийг дараах томьёогоор тооцно.

$$Ch = 0.14 \cdot C_p$$



ШУТИС-ийн Захирлын 2018 оны 08 дугаар сарын  
23.-ны өдрийн 11:30-т тоот тушаалтын хавсралт

- 3.1.11. Магистр, докторын түвшний сургалтын ажлын багшид ноогдох кредитийг тухайн хичээлийг сонгосон магистрант, докторантын тооноос хамааруулан дараах томьёогоор тодорхойлно.

Магистрант, докторантын тоо  $N_i \leq 15$  бол:

$$Ch = \sum_{i=1}^n \left[ (Ch_{lects,i} + Ch_{sem,i} + Ch_{lab.dad,i}) \cdot d_i \cdot \frac{N_i}{16} \right]$$

Магистрант, докторантын тоо  $N_i > 15$  бол

$$Ch = \sum_{i=1}^n [(Ch_{lects,i} + Ch_{sem,i} + Ch_{lab.dad,i}) * d_i] - 0.2$$

Энд:

$n$ - Тухайн улиралд багшийн заасан хичээлийн тоо,

$i$ - Хичээлийн дугаар,

$N_i$ -  $i$ -р хичээлийг сонгосон оюутны тоо,

$Ch_{lects,i}$ -  $i$ -р хичээлийн лекцээс багшид тооцогдсон кредит,

$Ch_{sem,i}$ -  $i$ -р хичээлийн семинараас багшид тооцогдсон кредит,

$Ch_{lab.dad,i}$ -  $i$ -р хичээлийн лаборатори ба дадлагаас багшид тооцогдсон кредит,

$d_i$ - $i$ -р хичээлийн агуулгын түвшинд харгалзах итгэлцүүр,

магистрын хичээлүүдэд  $d_i = 1.4$

докторын хичээлүүдэд  $d_i = 1.5$  байна.

- 3.1.12. Докторантын эрдмийн зэрэг горилсон бүтээлийг удирдах, хамгаалулахтай холбоотой кредитийг дараах байдлаар тооцож, нэг кредитийн хөлсийг гэрээт багшийн үнэлгээгээр бодож олгоно. Үүнд:

- Зэрэг горилсон бүтээлийг удирдахад ажил бүрд 2 кредит,
- Бүтээлд албан ёсны шүүмж бичихэд шүүмжлэгч бүрд 0.4 кредит,
- Зөвлөх комиссын гишүүнээр ажилласан багшид 0.4 кредит,
- Урьдчилсан хамгаалалтын хуралд оролцсон гадны байгууллагын гишүүд ба жинхэнэ хамгаалуулах зөвлөлийн орлогч дарга, гишүүдэд 0.2 кредит,
- Мэргэжлийн нэгдсэн шалгалт авсан комиссын гишүүдэд 0.2 кредит,
- Хамгаалуулах зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарт 0.5 кредитийг сургалтын ажлын хэсэгт тооцох.

- 3.1.13. Доктор, магистр, бакалаврын түвшний сургалтанд онлайн хэлбэрээр суралцаж буй, нэг хичээлээр 40 хүртлэх оюутнуудад хичээл заасан багш нарын кредитийг тооцоходо өдрийн сургалтын дээрх аргачлалуудаар бодож, гарсан үр дүнг онлайн сургалтын итгэлцүүр ( $K_{o/c}$ )-ээр үржүүлэн багшид ноогдох кредитийг тооцно. Онлайн сургалтын энэхүү итгэлцүүр нь бакалаврын түвшний сургалтанд  $K_{o/c}=1.2$ , магистр, докторын түвшний сургалтанд  $K_{o/c}=1.3$  байна. Онлайн сургалтанд хичээл заасан багшийн үнэлгээг 2.5 заалтаар, сургалтын заавал биелүүлэх кредитээс тусад нь тооцно.

- 3.1.14. Бакалавр, магистр, докторын сургалтын хөтөлбөрт тусгагдсан хэлний мэргэжлийн бус хичээлүүдийг сургалтын ажлын зайлшгүй шаардлагаар гадаадын аль нэг хэл дээр, бүрэн заасан тохиолдолд дээрх аргачлалуудаар бодож, багшид тооцогдох кредитийг 50 хүртэл хувиар нэмэгдүүлэн тооцно. Нэмэгдүүлэх хувийн хэмжээг салбар, тэнхимийн эрхлэгч, бүрэлдэхүүн сургуулийн дэд захирал тогтооно.
- 3.1.15. Өвөл, зуны сургалтад хичээл заасан багш нарын кредитийн тооцоог доорх томьёогоор бодож, үнэлгээг 2.5 заалтаар, сургалтын заавал биелүүлэх кредитээс тусад нь тооцно. Өвөл, зуны сургалт зөвхөн дээд боловсролын ба мэргэжлийн суурь хичээлүүдээр зохион байгуулагдана.

$$Ch = \sum_{i=1}^n [(Ch_{lects,i} + Ch_{sem,i} + Ch_{lab.dad,i}) \cdot d_i]$$

Энд:

$n$  - багшийн өвөл, зуны сургалтанд заасан хичээлийн тоо,

$i$  - хичээлийн дугаар,

$Ch_{lects,i}$ - Тухайн хичээлийн лекцээс багшид тооцогдсон кредит,

$Ch_{sem,i}$ - Тухайн хичээлийн семинараас багшид тооцогдсон кредит,

$Ch_{lab.dad,i}$  -Тухайн хичээлийн лаборатори ба дадлагаас багшид тооцогдсон кредит,

$d_i$ - Хичээлийн агуулгын түвшинд харгалзах итгэлцүүр:

Дээд боловсролын суурь болон мэргэжлийн суурь хичээлүүдэд  $d_i = 1.0$  байна.

- 3.1.16. Сургалтын мастер нь хичээлийн хөтөлбөрийн дагуу 6 хүртэл кредитийн лабораторийн хичээл зааж болно. Гүйцэтгэлийн илүү кредитийн үнэлгээг 3.1.17. заалтаар тооцно. Бүрэлдэхүүн сургуулийн захирлын туслах, салбар, тэнхимийн эрхлэгчийн туслах, сургалтын албаны ажилтан хичээл заахыг зөвшөөрөхгүй.
- 3.1.17. Цагийн сургалтанд хичээл заасан багш нарын кредитийн тооцоог 3.1.1 заалтын дагуу бодож, цагийн болон докторын сургалтанд хичээл заасан багш нарын нэг кредитийн үнэлгээг хамтын гэрээний заалтыг баримтлан олгоно.
- 3.1.18. Мэргэжлийн багш хүрэлцэхгүй байгаа тохиолдолд магистраас доошгүй зэрэгтэй, тухайн мэргэжлийн хүнийг гэрээт багшаар ажиллуулж болно. Гэрээт багшийн сургалтын ажлын кредитийг үндсэн багшийн ажлын кредит тооцох аргачлалын дагуу бодно.
- 3.1.19. Гэрээт багшийн сургалтын ажлын нэг кредитийн үнэлгээ болон нэгдсэн шалгalt авсан комиссын гишүүд, гадны байгууллагад ажилладаг эрдэмтэн, судлаачдыг урьж, нэг удаагийн лекц уншуулахад олгох хөлсийг тухайн багш, судлаачийн эрдмийн зэрэг цолоос хамааруулан дараах хувь хэмжээг баримтлан олгоно.

Хүснэгт 3

№	Эрдмийн зэрэг цол	Нэг кредитийн үнэлгээ
1	Шинжлэх ухааны доктор(Sc.D)	Профессорын албан тушаалын нэг кредитийн үнэлгээний 30 хувиар

2	Доктор(Ph.D)	Дэд профессорын албан тушаалын нэг кредитийн үнэлгээний 30 хувиар
3	Магистр, зөвлөх болон мэргэшсэн инженер	Багшийн албан тушаалын нэг кредитийн үнэлгээний 30 хувиар

3.1.20. Гадны байгууллагаас бакалавр, магистрын төгсөлтийн ажил удирдсан, зөвлөсөн, шүүмж бичсэн, дадлага удирдсан, төгсөлтийн шалгалтын комисст ажилласан хүмүүсийн нэг кредитийн үнэлгээг багшийн албан тушаалын нэг кредитийн үнэлгээний 40 хувиар тооцно.

3.2. Эрдэм шинжилгээ, инновацийн ажлын /Б/ кредитийг дараах байдлаар тооцно. Үүнд:

3.2.1. Эрдэм шинжилгээ, инновацийн ажлыг тооцох үзүүлэлтүүд

Хүснэгт 4

№	Эрдэм шинжилгээний өгүүлэл	Хэмжих нэгж	Кредит	Тайлбар
<b>I. Гадаадад ЭШ-ний өгүүлэл хэвлүүлэх</b>				
1	Томсон-Ройтерсийн индекс/IF-JCR/-тэй олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1-р зохиогчид	5 хүртэл	Тухайн албан тушаалд харгалзах Б цагийг бүтэн тооцно.
2	Томсон-Ройтерсийн индекс/IF-JCR/-тэй олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	2 ба бусад зохиогчид	5	
3	Томсон-Ройтерсийн индекс/IF-JCR/-гүй боловч мэргэжлийн түвшинд хянаагдаг /peer-review/ сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1	3	
4	Мэргэжлийн түвшинд хянаагдаггүй гадаадын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1	2	
5	Гадаадад зохион байгуулсан олон улсын хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1	1	
<b>II. Дотоодод ЭШ-ний өгүүлэл хэвлүүлэх</b>				
1	Их сургуулиудын эрдэм шинжилгээний бичигт өгүүлэл хэвлүүлэх	1	1	
2	Мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	1	1	
3	Дотоодод зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд бүрэн хэмжээний өгүүлэл хэвлүүлэх	1	1	
4	Дотоодод зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд илтгэлийн хураангуй хэвлүүлэх	1	0.5	

<b>III. Эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлэх</b>				
1	Монограф /нэг сэдэвт зохиол/	1 х.х.	0.3	
2	Гадаад хэлээр бичигдсэн монограф	1 х.х.	0.4	
3	Шинжлэх ухааны доктор /Sc.D/-ын диссертаци	1 ажил	7	
4	Доктор /Ph.D/-ын диссертаци	1 ажил	5	
5	Сурах бичиг /ШУТИС-ийн үндсэн сурах бичиг/	1 х.х.	0.2	
6	Орчуулгын бүтээл /ШУТИС-ийн захиалгат/	1 х.х.	0.2	
7	Гарын авлага /лабораторийн заавар тооцогдохгүй/	1 х.х.	0.2	
8	Эшлэл татагдсан бүтээл - Олон улсад - Томсон-Ройтерсын судалгааны мэдээллийн сан, Скопус	1 эшлэл	0.2 1	
<b>IV. Эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх</b>				
1	Олон улсын ( аман/үзүүлэн)	1 илтгэл	2	
2	Улсын (аман/үзүүлэн)		1.5	
3	Их сургуулийн (аман/үзүүлэн)		1	
<b>V. Оюуны өмчийн эрх авах, баталгаажуулах</b>				
1	Шинэ бүтээлийн патент (гадаадад/дотоодод)	1 бүтээл	5/2	
2	Ашигтай загвар (гадаадад/ дотоодод)		3/1	
3	Бүтээгдэхүүний загвар (гадаадад/ дотоодод)		3/1	
4	Барааны тэмдэгт (гадаадад/ дотоодод)		2/1	
5	Зохиогчийн эрх авсан бүтээл		1	
<b>VI. Бусад</b>				
1	Хөтөлбөр магадлан итгэмжлүүлэх (олон улсын / үндэсний )	1	2/1	

3.3. Профессор багш нарын сургууль, олон нийтийн үйлчилгээ /В цаг/-ний ажлын гүйцэтгэлийг дараах агуулгаар тооцно.

Хүснэгт 5

№	Ажил	Үр дүн*
I	Сургуулийн удирдлага, зохион байгуулалттай холбоотой ажлууд	
	ШУТИС-ийн болон бүрэлдэхүүн сургуулийн эрдмийн зэвлэлийн гишүүн /давхардуулж тооцож болно/	0.3
	Бүрэлдэхүүн сургуулийн захиргааны шийдвэрээр хийсэн ажил:	0.3

ШУТИС-ийн Захирлын 2018 оны 08 дугаар сарын  
25.-ны өдрийн 11:15-т тоот тушаалын хавсралт

	- Сургалт, заах арга, сургалтын технологийг боловсронгуй болгох - Заавар, дүрэм, бусад баримт бичиг боловсруулах - Бусад үүрэгт ажил	
II	Багшийн хөгжил, хамт олны төлөвшилтэй холбоотой ажлууд	
	Багшийн хичээлд сууж, зөвлөгөө өгөх, эсвэл багшийг дагалдуулах, хичээлд нь суух /1 хичээлийн улиралд/	0.3
1.	Нээлттэй хичээл зохион байгуулах	
2.	Хамт олны дунд нийгмийн арга хэмжээ зохион байгуулах, оролцох: - Урлагийн үзлэг наадам - Спортын тэмцээн, уралдаан - Хамт олны тэмдэглэлт арга хэмжээ	
III	Оюутан, суралцагчдын хөгжил, төлөвшилтэй холбоотой ажлууд	
3.	Оюутны дугуйлан, клуб удирдах, зохион байгуулах	
4.	Суралцагчдын хүмүүжил, төлөвшлийн ажил	
5.	Соёл, олон нийтийн ажил зохион байгуулах	0.3
IY	Сургуулийн нийгэмд үзүүлэх үйлчилгээтэй холбоотой ажлууд	
6.	Нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх зорилго бүхий эрдэм шинжилгээний хялбаршуулсан ба сурталчилгааны өгүүлэл хэвлүүлэх	
7.	Нийтэд мэдлэг түгээх, нийгмийг соён гэгээрүүлэх чиглэлээр лекц унших	
8.	ШУТИС-ийн эрдэм шинжилгээний ажлын бүртгэлд тусгагдаагүй эрдэм шинжилгээний төсөл, гэрээт ажилд оролцох	0.3
9.	Нийгэм, олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа Телевиз, радиогийн нэвтрүүлэгт оролцож, мэргэжлээ сурталчлах, мэргэжил, аргазүйн зөвлөгөө өгөх Өдөр тутмын сонин хэвлэлд өгүүлэл, нийтлэл бичих Үндэсний зөвлөхөөр ажиллах Шинжээчээр ажиллах Ажлын хэсгийн гишүүнээр ажиллах /ажлын хөлс авахгүй нөхцөлд/	
10.	Салбар /тэнхим/, профессорын багийн болон бусад семинар, лекц, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад оролцсон	0.003
11.	Зөвлөх багшаар ажиллах (30 хүртэл/30 дээш оюутан)	1/2
12.	Бусад	0.3

Жич: Энэхүү журамд дараах нэмэлт, өөрчлөлтүүдийг тусгасан.

- Ректорын 2016 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн A/05 тоот тушаалаар оруулсан өөрчлөлт
- Эрдмийн зөвлөлийн 2016 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 15 тоот тогтоолоор оруулсан өөрчлөлт
- Ректорын 2017 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн A/115 тоот тушаалаар оруулсан өөрчлөлт
- Эрдмийн зөвлөлийн хуралдааны 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 07 тоот тогтоолоор оруулсан өөрчлөлт